УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2022/136/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2022 он


Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Р.Аюуш

Утас: 70453721, Цахим хаяг: Ayushr@audit.gov.mn


---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт.. ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
3. Аудитын тайлан ........ 12
   3.1 Ерөнхий зүйл ........ 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
   3.4 Материаллаг байдал ........ 13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 15
   3.8 Аудитын гол асуудал ........ 15
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
4. Аудитын илрүүлэлт ........ 16
   4.3 Албан шаардлага ........ 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ .17


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/136/НА-СТА-ТНЗ
танай ____________-ны №______________-т

БАРУУНТУРУУН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ШИНЭБАЯР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллэс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болович материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

0200200359

## 2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **99,822,365.90** | **101,248,953.64** |
| **33** | **АВЛАГА** | 1,400,000.00 | 1,449,177.74 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,400,000.00 | 1,449,177.74 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 98,422,365.90 | 99,799,775.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 98,422,365.90 | 99,799,775.90 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 15,090,800.00 | 15,268,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 75,058,259.90 | 75,521,459.90 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,980,000.00 | 419,400.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,530,000.00 | 2,530,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,763,306.00 | 6,060,716.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,908,979,558.92** | **2,828,240,797.52** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,908,979,558.92 | 2,828,240,797.52 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,850,347,558.92 | 2,770,008,797.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,814,222,108.43 | 2,814,222,108.43 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -147,446,106.66 | -207,470,996.34 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,225,000.00 | 21,225,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -9,300,000.00 | -12,600,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 320,157,582.66 | 338,243,934.66 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -228,831,027.37 | -251,100,683.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 149,409,608.29 | 149,409,608.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -87,356,134.13 | -100,186,701.47 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 535,800.00 | 535,800.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -535,800.00 | -535,800.00 |
| 39217 | Ном | 18,266,527.70 | 18,266,527.70 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 58,632,000.00 | 58,232,000.04 |
| 39301 | Програм хангамж | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -400,000.00 | -799,999.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 56,632,000.00 | 56,632,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,008,801,924.82** | **2,929,489,751.16** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **426,717.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 426,717.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 426,717.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 426,717.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,008,375,207.82** | **2,929,489,751.16** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,008,375,207.82 | 2,929,489,751.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 788,160,200.52 | 788,160,200.52 |
| 51101 | Өмч: - төрийн | 788,160,200.52 | 788,160,200.52 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 817,448,227.99 | 738,562,771.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 817,448,227.99 | 817,448,227.99 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -78,885,456.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,402,766,779.31 | 1,402,766,779.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,008,801,924.82** | **2,929,489,751.16** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2. АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,362,556,100.00** | **1,260,318,999.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **63,976,000.00** | **3,586,352.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 63,976,000.00 | 3,586,352.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 63,976,000.00 | 3,586,352.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 63,976,000.00 | 3,586,352.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **200,088,900.00** | **214,437,547.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 190,088,900.00 | 209,315,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 190,088,900.00 | 209,315,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,098,491,200.00 | 1,042,295,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,000,000.00 | 5,122,247.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 5,122,247.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,377,725,303.93** | **1,339,204,455.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,377,725,303.93** | **1,339,204,455.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,274,958,601.82 | 1,284,293,509.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 839,102,567.34 | 831,522,403.14 |
| 210101 | Үндсэн цалин | 570,554,538.28 | 612,815,328.17 |
| 210102 | Нэмэгдэл | 190,789,881.06 | 173,305,447.64 |
| 210104 | Урамшуулал | 68,346,948.00 | 38,681,627.33 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,411,200.00 | 6,720,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,389,009.75 | 105,977,403.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,354,048.34 | 74,588,350.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,370,797.28 | 8,719,320.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,681,334.80 | 6,326,897.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,646,224.66 | 1,532,624.18 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,336,604.67 | 14,810,211.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 176,944,596.00 | 201,630,944.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,515,196.00 | 5,446,123.00 |
| 210302 | Түлш, халаалт | 172,187,400.00 | 196,073,221.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 242,000.00 | 111,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,873,894.00 | 9,636,627.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 199,700.00 | 339,947.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,314,600.00 | 3,432,280.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 392,900.00 | 157,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 375,294.00 | 620,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,685,600.00 | 4,004,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 905,800.00 | 1,082,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,480,440.00 | 25,573,518.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 277,850.00 | 518,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,202,590.00 | 24,073,018.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 982,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,960,000.00 | 2,529,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,960,000.00 | 2,529,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 294,000.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 294,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,243,000.00 | 1,302,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 500,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 403,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 583,000.00 | 399,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 111,965,094.73 | 105,826,613.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,914,600.00 | 7,001,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 107,050,494.73 | 98,825,113.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 102,766,702.11 | 54,910,946.25 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,751,900.00 | 31,982,382.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,751,900.00 | 30,397,482.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 1,584,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,403,498.11 | 16,057,608.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 86,403,498.11 | 16,057,608.25 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,611,304.00 | 6,870,956.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,611,304.00 | 6,870,956.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-15,169,203.93** | **-78,885,456.66** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-15,169,203.93** | **-78,885,456.66** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,298,580,100.00** | **1,256,732,647.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,298,580,100.00** | **1,256,732,647.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 190,088,900.00 | 209,315,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 190,088,900.00 | 209,315,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,098,491,200.00 | 1,042,295,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 10,000,000.00 | 5,122,247.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00 | 5,122,247.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,298,580,100.00** | **1,242,232,647.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,298,580,100.00** | **1,242,232,647.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,195,813,397.89** | **1,188,132,482.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 840,907,348.14 | 830,686,417.86 |
| 210101 | Үндсэн цалин | 572,359,319.08 | 559,588,882.01 |
| 210102 | Нэмэгдэл | 190,789,881.06 | 206,387,651.26 |
| 210104 | Урамшуулал | 68,346,948.00 | 54,692,144.59 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,411,200.00 | 10,017,740.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,389,009.75 | 106,659,283.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,354,048.34 | 76,421,749.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,370,797.28 | 8,139,816.53 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,681,334.80 | 5,863,294.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,646,224.66 | 1,424,211.13 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,336,604.67 | 14,810,211.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 178,982,596.00 | 199,663,344.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,515,196.00 | 5,446,123.00 |
| 210302 | Түлш, халаалт | 174,167,400.00 | 194,093,221.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 124,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,629,794.00 | 10,331,127.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 418,600.00 | 737,247.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,154,600.00 | 3,851,680.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 392,900.00 | 157,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 375,294.00 | 684,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,230,000.00 | 3,689,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,058,400.00 | 1,211,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 15,011,950.00 | 29,711,510.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 294,550.00 | 562,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,503,000.00 | 27,953,610.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,214,400.00 | 1,195,700.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 39,990,000.00 | 2,781,000.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,000,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,990,000.00 | 2,781,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 294,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 294,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,243,000.00 | 1,432,200.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 450,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 160,000.00 | 403,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 583,000.00 | 579,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,659,700.00 | 6,573,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,659,700.00 | 6,573,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **102,766,702.11** | **54,100,164.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,751,900.00 | 31,171,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 14,751,900.00 | 28,956,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 2,214,900.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,403,498.11 | 16,057,608.25 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 86,403,498.11 | 16,057,608.25 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,611,304.00 | 6,870,956.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,611,304.00 | 6,870,956.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **14,500,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **14,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **14,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 14,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 14,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-14,500,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 780,694,200.52 | 1,402,766,779.31 | 832,617,431.92 | 00.00 | 3,016,078,411.75 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **780,694,200.52** | **1,402,766,779.31** | **832,617,431.92** | **00.00** | 3,016,078,411.75 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 7,466,000.00 | 00.00 | -15,169,203.93 | 00.00 | -7,703,203.93 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **788,160,200.52** | **1,402,766,779.31** | **817,448,227.99** | **00.00** | 3,008,375,207.82 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **788,160,200.52** | **1,402,766,779.31** | **817,448,227.99** | **00.00** | 3,008,375,207.82 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **788,160,200.52** | **1,402,766,779.31** | **817,448,227.99** | **00.00** | 3,008,375,207.82 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -78,885,456.66 | 00.00 | -78,885,456.66 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **788,160,200.52** | **1,402,766,779.31** | **738,562,771.33** | **00.00** | 2,929,489,751.16 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|
| | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,251,610,400.00 | 1,228,681,835.75 | 22,928,564.25 | 98.2% |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,251,610,400.00 | 1,228,681,835.75 | 22,928,564.25 | 98.2% |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,221,071,700.00 | 1,198,210,235.75 | 22,861,464.25 | 98.1% |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 834,063,500.00 | 830,686,417.86 | 3,377,082.14 | 99.6% |
| Үндсэн цалин | 566,878,800.00 | 559,588,882.01 | 7,289,917.99 | 98.7% |
| Нэмэгдэл | 202,339,800.00 | 206,387,651.26 | -4,047,851.26 | 102.0% |
| Урамшуулал | 54,764,900.00 | 54,692,144.59 | 72,755.41 | 99.9% |
| Гэрээт ажлын хөлс | 10,080,000.00 | 10,017,740.00 | 62,260.00 | 99.4% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 112,598,700.00 | 106,659,283.89 | 5,939,416.11 | 94.7% |
| Тэтгэврийн даатгал | 79,236,000.00 | 76,421,749.89 | 2,814,250.11 | 96.4% |
| Тэтгэмжийн даатгал | 8,340,700.00 | 8,139,816.53 | 200,883.47 | 97.6% |
| ҮОМШӨ-ний даатгал | 6,672,500.00 | 5,863,294.78 | 809,205.22 | 87.9% |
| Ажилгүйдлийн даатгал | 1,668,200.00 | 1,424,211.13 | 243,988.87 | 85.4% |
| Эрүүл мэндийн даатгал | 16,681,300.00 | 14,810,211.56 | 1,871,088.44 | 88.8% |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 200,515,300.00 | 199,663,344.00 | 851,956.00 | 99.6% |
| Гэрэл, цахилгаан | 6,121,500.00 | 5,446,123.00 | 675,377.00 | 89.0% |
| Түлш, халаалт | 194,093,800.00 | 194,093,221.00 | 579.00 | 100.0% |
| Цэвэр, бохир ус | 300,000.00 | 124,000.00 | 176,000.00 | 41.3% |
| **Хангамж, бараа материалын зардал** | 9,680,200.00 | 9,508,880.00 | 171,320.00 | 98.2% |
| Бичиг хэрэг | 418,600.00 | 415,400.00 | 3,200.00 | 99.2% |
| Тээвэр, шатахуун | 3,854,500.00 | 3,851,680.00 | 2,820.00 | 99.9% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 392,900.00 | 157,300.00 | 235,600.00 | 40.0% |
| Ном, хэвлэл | 679,000.00 | 684,000.00 | -5,000.00 | 100.7% |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,720,000.00 | 3,189,100.00 | -469,100.00 | 117.2% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,615,200.00 | 1,211,400.00 | 403,800.00 | 75.0% |
| **Нормативт зардал** | 34,974,800.00 | 29,711,510.00 | 5,263,290.00 | 85.0% |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 593,700.00 | 562,200.00 | 31,500.00 | 94.7% |
| Хоол, хүнс | 33,166,700.00 | 27,953,610.00 | 5,213,090.00 | 84.3% |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,214,400.00 | 1,195,700.00 | 18,700.00 | 98.5% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,800,000.00 | 15,781,000.00 | 6,019,000.00 | 72.4% |
| Багаж, техник, хэрэгсэл | 13,000,000.00 | 13,000,000.00 | 0.00 | 100.0% |
| Урсгал засвар | 8,800,000.00 | 2,781,000.00 | 6,019,000.00 | 31.6% |
| **Томилолт, зочны зардал** | 949,200.00 | 294,000.00 | 655,200.00 | 31.0% |
| Дотоод албан томилолт | 949,200.00 | 294,000.00 | 655,200.00 | 31.0% |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,995,200.00 | 1,432,200.00 | 563,000.00 | 71.8% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 450,000.00 | 50,000.00 | 90.0% |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 403,200.00 | 0.00 | 100.0% |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 579,000.00 | 21,000.00 | 96.5% |
| Газрын төлбөр | 492,000.00 | 00.00 | 492,000.00 | 0.0% |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4494800.00 | 4473600.00 | 21,200.00 | 99.5% |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,494,800.00 | 4,473,600.00 | 21,200.00 | 99.5% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 30538700.00 | 30471600.00 | 67,100.00 | 99.8% |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 30,538,700.00 | 30,471,600.00 | 67,100.00 | 99.8% |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,023,800.00 | 28,956,700.00 | 67,100.00 | 99.8% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,514,900.00 | 1,514,900.00 | 0.00 | 100.0% |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,251,610,400.00 | 1,228,681,835.75 | 22,928,564.25 | 98.2% |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,251,610,400.00 | 1,228,681,835.75 | 22,928,564.25 | 98.2% |
| Улсын төсвөөс санхүүжих | 209,315,300.00 | 202,444,344.00 | 6,870,956.00 | 96.7% |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,042,295,100.00 | 1,026,237,491.75 | 16,057,608.25 | 98.5% |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **5,122,247.00** | **(5,122,247.00)** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **5,122,247.00** | **(5,122,247.00)** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 4,422,247.00 | **(4,422,247.00)** |
| **Хангамж, бараа материалын зардал** | | 822,247.00 | **(822,247.00)** |
| Бичиг хэрэг | | 321,847.00 | **(321,847.00)** |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 500,400.00 | **(500,400.00)** |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 1,500,000.00 | **(1,500,000.00)** |
| Тавилга | | 1,500,000.00 | **(1,500,000.00)** |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 2100000.00 | **(2,100,000.00)** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,100,000.00 | **(2,100,000.00)** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 700000.00 | **(700,000.00)** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | | 700,000.00 | **(700,000.00)** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 700,000.00 | **(700,000.00)** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 5122247.00 | **(5,122,247.00)** |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 5,122,247.00 | **(5,122,247.00)** |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 5,122,247.00 | **(5,122,247.00)** |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль нь энэ хичээлийн жилд хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх, багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 9 зорилт тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс хяналт, шалгалт хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20 ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 1,377,725.3 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,339,204.4 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 6,696.0 мянган төгрөгийн 80 хувиар буюу 5,356.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 79,312.2 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 1,400.0 | 1,449.2 | 49,2 |
| Бараа материал | 98,422.4 | 99,799.8 | 1,377.4 |
| Үндсэн хөрөнгө | 2,908,979.5 | 2,828,240.8 | -80,738.7 |
| **Нийт хөрөнгө** | 3,008,801.9 | 2,929,489.5 | -79,312.4 |
| Өр төлбөр | 0,00 | 247.8 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,008,375.2 | 2,929,489.7 | -79,312.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 3,008,375.2 | 2,929,489.7 | -79,312.4 |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 1,449.2 мянга болж 49.2 мянган төгрөгөөр өссөн нь хувь хүнээс авах авлага байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Бараа материалын дансны үлдэгдэл 99,799.8 мянган төгрөг болж 1,377.4 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал байна. Бараа материалын үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,828,240.8 мянган төгрөг болж 80,738.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 98,825.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 18,086.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,929,489.7 мянган төгрөг болж 79,312.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 102,237.2 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна.

Нийт зардал өмнөх оноос 46,675.9 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан нь хангамжийн материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,280,147.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг ирүүлсэн саналаас 90,109.5 мянган төгрөгөөр бууруулж 1,190,037.7 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 61,572.7 мянган төгрөгөөр өсгөн 1,251610.4 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,251,610.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,04,295.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 209,315.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,042,295.1 мянга, орон нутгийн төсвөөс 209,315.3 мянга, нийт 1,251,610.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,228,681.9 мянган төгрөгийг зарцуулж 22,928.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,228,681.8 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчаас 5,122.2 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан.

Аудитаар Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль нь нийт 1,256,732.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулахаас 77,096.5 мянган төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, 203,755.7 мянган төгрөгийн 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага өглөө.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэлээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 20 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тээвэр шатахууны зардал анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 667,200.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, шууд зардалд бүртгэсэн 385,718,0 сая, цалингийн урьдчилгаа суутгаагүй илүү олгосон 219.2 мянган төгрөгийн алдааг тус бүр залруулж, Боловсрол, шинжлэх ухааны яамны "Боловсрол чанарын шинэчлэл"төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 630.0 мянган төгрөгийг нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэж шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мөрдөж ажиллаагүй 280,852.2 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн урьдчилгаа, тогтмол зардал, дотоод томилолт, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 385,498.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дэх хэсэгт заасныг зөрчин цалингийн урьдчилгааг суутгаагүй 219.2 мянган төгрөгийг авлагаар бүртгэлд тусгуулж залрууллаа.
3. Боловсрол, шинжлэх ухааны яамны "Боловсрол чанарын шинэчлэл"төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 630.0 мянган төгрөгийг нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

### 4.3 Албан шаардлага

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтад заасан "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг зөрчин орлогын 17,449.3 мянган төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 59,647.2 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 169,811.8 мянган төгрөгийн 3 гүйлгээ, зарлагын 33,943.9 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна. Иймд Шилэн дансны тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж мэдээллийг байршуулан, хугацаа хоцроохгүй байх алдаа зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага өгсөн.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баруунтуруун сумын Ерөнхий боловсролын сургууль | 4 | 667,200.2 | 3 | 385,718,0 | | | 1 | 280,852.2 | | |
| ДҮН | | 4 | 667,200.2 | 3 | 385,718,0 | | | 1 | 280,852.2 | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 02 сарын 24-ний өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ